

# МОНГОЛЫН ОРОН НУТГИЙН МЭДЭЭ

АЗИЙН БҮСИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

## Идэвх султай гишүүдийг аврах нь

Далын ахлагч, Азийн бүсийн ерөнхийлөгчийн хоёрдугаар зөвлөх Ларри Я.Вилсон

Зарим хүмүүс сүмд нэгдэж, хэсэг хугацаанд идэвхтэй явж байснаа сайн мэдээний замаар цаашид үргэлжлүүлэн замнахаа болиход хүрдэг. Энэ нь маш олон шалтгаанаас үүдэлтэй байдаг байна. Заримдаа тэд хэн нэгний хэлсэн эсвэл хийсэн зүйлд гомддог. Мөн зарим тохиолдолд тэд хуучин зуршлуудаа давтаж, сайн мэдээний жишгүүдийн дагуу амьдрахгүй байгаадаа ичдэг. Эсвэл ажил болон сүмд явах дадал хэвшил нь алдагдсанаар зөрчиддөөнтэй тулгардаг. Хүмүүс идэвх султай болдог бусад олон шалтгаан бий.

Бидний олонх нь энэ замаар аялж буй хэн нэгнийг мэддэг шүү дээ. Их Эзэн алдагдсан хоньдын тухай сургаалт үлгэр ярихдаа эдгээр хүмүүсийн талаар мэдэж байжээ. Алдагдсан нэг хонийг аврахын тулд Их Эзэн ерэн есөн хонио орхисон нь үүнийг бүр илүү ойлгомжтой болгосон юм. Тэр биднээс Өөртэйгөө адил үйлдэл хийхийг хүсдэг.

Бид энэ сэдвээр үйлчлэлийнх нь бүхий л цаг үеүдэд ерөнхийлөгч Монсоноос сонссоор ирсэн билээ. Тэрээр саяхан хэлэхдээ: “Ерөнхий эрх мэдэлтнээр үйлчилсэн энэ хэдэн жилийн хугацаанд сайн мэдээний өгч чадах бүхий л



Ахлагч  
Ларри  
Я.Вилсон

адислалуудаас ах эгч нарыг маань холдуулж болзошгүй янз бүрийн нөхцлүүдээс тэднийг ‘аврах’ хэрэгцээг би онцгой анхаарсаар ирсэн” гэжээ. Сүмийн ерөнхийлөгч болсноосоо хойш бид авралын энэхүү ажилд оролцохоор илүү яарах хэрэгтэйг би илүү их мэдэрсэн юм. Сүмийн итгэлтэй гишүүд хайр ба ойлголтоор гараа сунгаснаар олон хүн бүрэн идэвхжин, эргэж ирсэн ба тэд одоо амьдралд нь нэмэгдсэн адислалууддаа баярладаг. Энэ талаар хийх зүйл маш их байгаа бөгөөд би бүх хүмүүсийг гараа сунган авралын ажлаа үргэлжлүүлэхийг урамшуулан дэмжиж байна.

Их Эзэн ‘Чи нэгэн цагт дахин эргэж, ах дүүсээ батжуул’ (Лук 22:32) гэсэн билээ.

Авралын энэхүү үйл явц эцэг эхэд маань тохиолдсон юм. Сайн гэрийн багш болон бусад сайхан сэтгэлт гишүүдийн хичээл зүтгэлээр тэд маань сүмд эргэн ирж, бүрэн идэвхтэй болсон билээ. Дэлхийн өөр бусад газруудад гишүүдтэй ярьж байхдаа эцэг эхийн минь байсан шиг яг тийм нөхцөл байдлаас аврагдсан олон гишүүд байдгийг олж мэддэг юм. Хэн нэг нь зориглож, тэдэнд гараа сунган хичээл зүтгэл гаргасаар байна.

Өсвөр насны хөвгүүн байх үед надад аавынхаа гэрийн багшийн хамтрагчаар үйлчилж, хэн нэгнийг хэрхэн аварч болохыг ажиглах боломж олдсон юм. Биднийг манай тойргийн идэвх султай нэгэн гэр бүлд оноосон байв. Тэд сүмд нэгдээд олон жил болж байжээ. Хамгийн анх тэдэн дээр айлчилж очиход биднийг хүйтэн хөндий хүлээн авч байсныг би сайн санадаг. Аав маань арын хашаанд нь байсан тэдний ногооны цэцэрлэгийг хараад цэцэрлэгтээ юу ургуулж байгааг нь асуусан юм. Тэд биднийг гарч, цэцэрлэгээр хамт алхахыг санал болголоо.

Бидэнд юу ургуулж байгаагаа үзүүлэх явцад энэ хосууд ба аавын хооронд харилцаа үүсч эхэлж байгааг би ойлгосон юм. Дараагийн удаа тэднийд очоод удалгүй итгэл, хайрын харилцааг цэцэглүүлэх

халуун дулаан мэдрэмж хөгжиж эхэлснийг би анзаарсан билээ. Энэ нь тэднийг сүмдээ идэвхтэй болоход урих боломжийг аавд минь олгосон юм. Тэд түүний урилгад хариулж, гайхалтай найзууд нь болсон билээ. Ийнхүү эцэг эх маань ижил нөхцөлд байгаа бусад хүмүүст хэрхэн туслах талаар туршлагатай болсон юм.

Саяхан би Бангкок дахь манай сүмийн дөрвөн бишопын нэгтэй нь бусдыг аврахаар тойрогтоо гаргаж байгаа хичээл зүтгэлийнх нь талаар ярилцсан юм. Хайраар дүүрэн байж, түүнийгээ бусдад үзүүлэх арга замыг олсон үедээ айлчлан очих юм бол бидний хичээл зүтгэл хамгийн үр дүнтэй байдаг хэмээн тэрээр онцлон хэлж билээ. Аав маань тэр гэр бүлийн арчилж хамгаалдаг зүйлийг сонирхон асуух үед энэ арга зам олдсон юм.

Бангкокийн өөр нэгэн бишоп бусдыг аврахаар хэрхэн явах талаар надтай нэгэн үнэ цэнэтэй зөвлөгөөг хуваалцсан юм. Бид хүмүүсийг сүмдээ эргэн ирэхэд зөвхөн уриад зогсохгүй, тэд яагаад үүнийг хийх ёстой гэдгийг ойлгоход нь туслах хэрэгтэй гэж тэр тайлбарласан. Мөн бид Аврагчийн мөнхийн итгэл найдвар, баяр баясгалангийн захиасыг тэдэнд авчрах хэрэгтэй. Энэ бишоп Бурхантай хийсэн гэрээгээ шинэчилснээр ирдэг хүчээр дамжуулан амьдралд орж ирдэг сайн сайхан зүйлүүдийг тэдэнд заахын чухал ач холбогдол болоод Аврагчийн сургаалын дагуу амьдрахаар хичээж байгаа тэдгээр хүмүүстэй холбоо тогтоосноор ирдэг хүч чадлын

талаар онцлон хэлсэн. Сүмд явснаар ирдэг адислалуудыг тайлбарлах үедээ бидний урилгад хариулж байгаа идэвх султай тэдгээр хүмүүсийг бид илүү тодоор олж харах боломжтой болно.

Бид бусдыг аврах ажилд явахдаа ерөнхийлөгч Монсоны үүнийг хэрхэн хийх талаар онцлон хэлсэн гол зарчмуудыг санадаг байх хэрэгтэй. Тэр сүмийн ерөнхий эрх мэдэлтнүүдийн хурлууд дээр үг хэлэхдээ Их Эзэний алдагдсан хоньдыг эрж хайхын ач холбогдлын талаар л ихэвчлэн ярьдаг. Тэр бусдыг аврахад бидэнд хэрэгтэй гэж үзсэн тодорхой түлхүүрүүдийг хуваалцдаг. Хүмүүсийг буцаж ирэхийг урихаас гадна бид тэдэнд үйлчлэл хийж, утга учиртай ямар нэгэн зүйлийг өгөх хэрэгтэй гэж түүний хэлэхийг би олонтоо сонссон. Энэ нь тэдэнд хүнд дарамт болохооргүй тийм нэгэн утга учиртай зүйл байх хэрэгтэй юм.

Нэмж хэлэхэд, бид тэдэнд өгсөн хариуцлага, үүрэг даалгавраараа дамжуулан тэднийг амжилттай байхад нь туслах хэрэгтэй гэж хэлсэн.<sup>3</sup> Ерөнхийлөгч Монсоны энэ зөвлөгөөг дагах нь агуу мэргэн ухаан билээ. Сүмдээ эргэн ирж байгаа хэн нэгэн хичээлийн жижиг хэсгийг заах эсвэл туршлагатай гишүүний дуудлагаа хэрхэн биелүүлж байгааг ажигласнаар туршлага хуримтлуулан, сурах боломж олгохын тулд тэдэнд багшийн эсвэл удирдагчийн туслахаар үйлчлүүлэхээр дуудаж болно.

Эцэст нь сүмдээ идэвхтэй болж, эргэн ирж байгаа сүмийн гишүүд маань бидэнд хэрэгтэй гэдгээ өөрсдөө ойлгох

хэрэгтэй. Тэдний оролцоо нь ямар ч салбар, тойрог дахь гэгээнтнүүдийн нэгдэлд хүч нэмэх болно. Тэдний итгэл, үйлчлэл бусдын амьдралд эерэг өөрчлөлтийг бий болгож чадна. Хоёр дахь ирэлтээр Аврагчийг хүлээн авах зохистой хүмүүс болон хамтдаа өсч хөгжих үед бүх хүмүүс баяжигдан нэмэгдэж мөн адислагдах болно.

Сургаал ба Гэрээ номонд Их Эзэн бидэнд хэлэхдээ “Мөн хэрэв та нар энэ хүмүүст наманчлалыг тунхаглахад өөрсдийн бүхий л өдрүүдэд хөдөлмөрлөж мөн зөвхөн нэг бодгалийг надад авчрах аваас, миний Эцэгийн хаант улсад түүнтэй хамт та нарын баяр хөөр хэчнээн агуу байх билээ! Мөн эдүгээ, хэрэв миний Эцэгийн хаант улсад надад авчирсан нэг бодгальтай хамт та нар агуу баяр хөөртэй байх аваас, хэрэв та нар олон бодгалийг надад авчрах юм бол та нарын баяр хөөр хичнээн агуу байх билээ!” (С ба Г 18:15-16) гэжээ.

Идэвх султай гишүүдийг буцаан авчрах нь сүрдмээр ажил мэт санагдаж болох юм. Гэсэн хэдий ч амьдралд бүх зүйл байдгийн адилаар Их Эзэн итгэлээрээ Өөртөө ирэх тэдгээр хүмүүст замыг нээх болно. Тэд сайн мэдээний захиасыг хуваалцах зөв цаг, урилга өгөх зориг мөн алдагдсан хоньдыг аврахаар Түүний жишээг дагах үед юу тохиолдож болохыг харах алсын хараа, Их Эзэний тэдэнд хэлэх үгсээр нь Түүнийг олох болно. Бид амьд бошиглогчийн зөвлөгөөнд анхаарал тавьж, “аврахаар явж буй” тэдний дунд байх болтугай хэмээн би залбирч байна. ■

## “Бурханы алдар суу бол оюун билиг ... гэрэл ба үнэн юм” (С ба Г 93:36)

Орон нутгийн сэтгүүлийн редактор Н.Пүрэвсүрэн

**2013** оны 6 сарын 23-ны өдөр Баянзүрх байрны цуглааны танхим ХҮГ залуусаар дүүрэн байлаа. Тэд Бригам Янгийн Их Сургуулийн захирал Стивен Вийлпрайт болон Дэвид Дуули нартай хийсэн галын дэргэдэх цугларалтад оролцохоор яаран ирсэн нь энэ аж.

Энэ уулзалтаар тэд эрдэм боловсрол яагаад чухал болох мөн юунаас, хэрхэн суралцах талаар болон сүмийн боловсролын системийн утга учир, зорилго болоод ялангуяа Бригам Янгийн Их Сургуулийн элсэлт, хэрхэн хөтөлбөрт хамрагдах,

ямар шаардлагыг хангах ёстой талаар тодорхой мэдээлэл хүлээн авлаа. Зочдыг үг хэлсний дараа чөлөөт ярилцлага болж, сонирхсон асуултууддаа хариулт авав.

Их Эзэний зарлигласны дагуу хүн бүр өөрөөсөө шалтгаалах бүхнээ хийж, боловсролтой болох нь авралын төлөвлөгөөний нэгэн чухал хэсэг билээ. Сайн мэдээний мэдлэгээс гадна боловсролтой болоход нь гэгээнтнүүдээ дэмжих зорилгоор Бошиглогч Бригам Янгийн санаачлагаар байгуулагдсан сүмийн сургуулиудад олон залуус боловсрол олж авч, янз бүрийн салбарт

амжилт гаргаж, өөрсдөдөө болон гэр бүл, нийгэмдээ тус дэм үзүүлсээр байна. Энэ үйлсийг дэмжин туслахаар сүмийн арван тав дахь ерөнхийлөгч Гордон Б.Хинкли тасралтгүй үргэлжлэх сургалтын санг байгуулсан нь олон гэгээнтний амьдралд адислал болсоор байгаа билээ. Сүмийн боловсролын систем ба Бригам Янгийн Их Сургуулийн талаар сонирхсон гишүүд СБС-ийн ажилтантай уулзах эсвэл сүмийн <http://www.lds.org> сайтаар орон, ВYU (Бригам Янгийн Их Сургууль) гэж хайн орж, нэмэлт мэдээллүүдийг авч болно. ■



*БЯИС-ийн захирал Стивен Вийлпрайт, Вийлпрайт эгч, Дэвид Дуули*



# Монголын Өсвөр үеийнхний гар тэрэгний анхны аян

Орон нутгийн сэтгүүлийн редакторын туслах Э.Намуун

Сүмийн өсвөр үеийнхний 2013 оны чуулганд Улаанбаатар Баруун гадас, Зүүн дүүрэг, Дархан дүүрэг ба Номлолын дүүргийн нийт 21 салбар, тойргийн 320 залуу өөрсдийн удирдагчдын хамт мөн сүмийн удирдагчид, аяныг зохион байгуулагч хорооныхон, гурван хос ахмад номлогчид нийлсэн бараг 400-гаад гишүүн оролцлоо. Монголын өсвөр үеийнхний чуулган дөрвөн жилд нэг удаа зохион байгуулагдах бөгөөд энэ удаагийн чуулган “Ариун газруудад зогсогтун тэгээд бүү шилжин нүүлгэгд” (Сургаал ба гэрээ 87:8) гэсэн уриатай байв. Чуулганы гол зорилго нь анхдагчдын



гайхалтай үлгэр жишээ, түүхээс сүнслэгээр суралцаж, тэдний туулсан зовлон бэрхшээлийг аяныхаа явцад ухааран, мэдэрч, сүнслэг туршлага хуримтлуулан, цаашдын амьдралдаа



Үзэсгэлэнт  
Хайлантын ам

Амскийх  
зуураа  
суралцаж  
байгаа нь

Амттай хоол  
хийж өгч  
байсан гал  
тогооныхондоо  
баярлалаа



тулгарах саад бэрхшээлийг итгэлтэйгээр даван туулах урам зоригтой болох, цаашлаад өглөөний семинарт илүү олон хүүхдийг хамруулж, ирээдүйн бүрэн цагийн номлод болон Ариун сүмийн нандин ёслолуудыг хүлээн авахад бэлтгэх явдал байв. Мөн чуулганд хамрагдсан хүүхэд бүр гэр бүлийн түүхийн familysearch.org сайтад бүртгүүлж, гэр бүлийн түүхээ хөтлөх мөн нас барагсдыг аврах нь ямар агуу ажил болохыг мэдэж авах явдал байлаа.

Монголд анх удаа зохион байгуулагдаж буй гар тэрэгний энэ аян зуны дэлгэр сайхан цагт 2013 оны 7 сарын 1-нээс 5-ны өдрүүдэд Булган аймгийн Хялганат сумын Хайлантын ам хэмээх байгалийн үзэсгэлэн цогцолсон сайхан газарт

**Сайн мэдээ-  
нээс хамтдаа  
суралцсан нь**

**Тэргээ түрээд  
урамтайгаар  
алхацгаана**



**Гайхалтай аяны цуваа үргэлжилсээр**

зохион байгуулагдсан билээ. Байрлах газартаа ирсэн эхний орой залуусыг “Гэр бүлийн түүхийн” үдэш угтсан юм. Гэр бүлийн түүхийн ажлыг Монголд өрнүүлэн дэмжихээр ирсэн Ахлагч Фармер, Систер Фармер нар гэр бүлийн түүхээ хөтлөх, нас барагсдаа аврах ажлын ач холбогдлыг хөгжилтэй мөн бодитоор харах боломжтойгоор танилцуулсан нь тун гайхалтай ойлгуулж чадсан юм. Дараа нь галын дэргэдэх цугларалт болж, Улаанбаатар Номлолын Ерөнхийлөгч Кларк ах, эгч хоёртой дэлгэцээр уулзах боломжтой байлаа. Тэдний Монголд үйлчлэх хугацаа дуусч байгаа бөгөөд залуучуудад хандан ярьсан анхдагчдын тухай гайхамшигт түүх, сүнслэг яриа болон гэрчлэлийг сонсож, ариун сүнсийг мэдэрсэн билээ.

Өнгөрсөн 2012 онд Улаанбаатар Баруун гадас анх удаагаа гар тэрэгний аяныг зохион байгуулж байсан нь бидэнд том туршлага болж, бүх л аяны туршид бидний замыг зөв чиглүүлэн удирдаж байв. Залуучууд очсон газартаа хурдан





Гар тэрэгний аяны дайран өнгөрөх эхний өртөө "IOWA" ("АЙОВА") байв. Анхдагчдын туулсан замаар алхаж, зорьсон газартаа хүрэхэд нэг алхам ойртлоо гэж хүүхдүүд баясан ярьцгааж байв. Аялалын турш залуучууд Сүмийн бүхий л дууллыг урамтайгаар дуулж, сүнсэлэг хүч чадлаар дүүрэн байж чадсан билээ. Уул өөд өгсөж, ямар ч замгүй газраар мод сүлжин бууж, том жалгаар гарч, шаварт

дассан ч гар тэрэгний аялал эхлэх үед залуучууд танил бус газраар, ямар бартааг туулан, хэрхэн аялахаа ч мэдсэн юмгүй, хөөрч догдлон, цуваагаа даган явцгааж байлаа. Тэд тэргээ түрэн, хол замд алхахдаа хөл холгох, бороонд норох, наранд халах зэргээс халшраагүй ч ялаа, шумуул саад болж байсан юм.

**Бид бүгдийг чадна . . .**

унаж, хувцсаа шавар болгож, гутал углаашаа намагт шигдүүлэн гэж хөл нүцгэн алхаж байсан нь том сорилт байсан ч Бурханы Сүнсээр саад бэрхшээлээ даван туулсан юм. Эхний өдрийн хамгийн сүүлийн дайран өнгөрөх өртөө "NEBRASKA" ("НЕБРАСКА") байлаа. Хамгийн хүнд бартаат замыг бие биенийхээ тусламжтайгаар, нэг нэгнээсээ барин, хэлхээ үүсгэж, уулын эгц өгсүүр болон уруу газрыг даван гарч байв. Хамтын хүчээр саад бэрхшээлүүдийг давсан хүүхдүүд анхдагчдын туулсан зовлон бэрхшээлийг бага ч гэсэн мэдрэх боломжтой байсандаа талархалтай байсан юм.

**Хүндхэн сорилт**



**Сэлэнгэ мөрнийг гаталсан нь**



**Хамтын хүч**

Их аяны дараа ядарч сульдсан залуусыг орой нь Авьяас шоу угтлаа. Салбар, тойрог бүрийн авьяаслаг хүүхдүүд өөрсдийн бэлтгэсэн урлагийн үзүүлбэрээ толилуулсан юм.

Дараагийн өдрийн гар тэрэгний аян эхний өдрийнх шиг саадтай хэцүү зам байгаагүй ч аялах зам урт байв. Өргөн уудам тал нутгаар аялаар Хялганатын суурингийн хажуугаар гарч, жижиг горхийг саадгүй давж чадсан ч бүсэлхийнээс дээгүүр хүрэх гүнзгий голыг гатална гэж хүүхдүүд бодсонгүй. Сэлэнгэ голыг гатлахын тулд хүүхдүүд ачаагаа нэг нэгээр нь тэврэн, хөвгүүд зарим охидоо үүрч байсан юм. Гол гаталж, тэндээ буудаллан, өөрсдөө хоол хийж идэн, хэсэг зуур амсхийсний дараа буцаж, голоо гатлан, байрласан газар руугаа хөдөллөө. Залуучууд аяны туршид тулгарсан саад бүрийг ямар ч гомдлолгүйгээр даван туулж, итгэлээр жигүүрлэн урагш алхаж, бие биенээ дэмжин явж чадсан билээ. Их аяны дараа хүүхдүүдийг АХА буюу асуулт хариултын тэмцээн угтав. 2012-2013 оны Шинэ Гэрээний семинарт сурсан судрын мэдлэгээ шалгуулах онцгой боломж тэдэнд олдсон юм. Чингэлтэй, Мөрөн, Багануур салбарын 6 хүүхэд тунан үлдэж, институтын брэнд хос малгай, футбол-коор шагнуулсан юм.

Уг аяны үеэр олсон гайхамшигт туршлагаууд нь Бурханы агуу хайр ба энэрлийг ухаарахад мөн анхдагчдын туулсан зовлон бэрхшээлийг бага ч болтугай ойлгоход тусалсан юм. Залуучууд гар тэрэгний аянаар дамжуулан тэвчээртэй, эв нэгдэлтэй, тусч байснаар хамтдаа юут ч даван туулж чаддагийг сурч, мэдэж авсан билээ. ■

## Та нар бүх дэлхийгээр явагтун

Ахмад номлогчид Ахлагч ба Систер Гросбек

Монголын зүүн хязгаарт Орших Дорнод нутгийн Чойбалсан салбар номлогчийн сүнсийг мэдэрсэн гайхалтай 150 гишүүнтэй. 1998 онд салбар байгуулагдсанаас хойш энэ жижиг нэгжээс 60 гаруй залуус бүрэн цагийн номлолд үйлчилж, тэдний гуравны нэг нь Америкийн Нэгдсэн Улс, Орос, Африк, Балтикийн улс орнууд болон Австрали зэрэг гаднын улс орнуудад, үлдсэн гуравны хоёр нь төрөлх хэлээрээ монголчууддаа сайн мэдээг заасан байна. Монголд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойн баярын үед зохион байгуулагдсан эргэж ирсэн номлогчдын

уулзалтанд тэдний цөөхөн нь ирсэн юм.

Салбарын ерөнхийлөгч 17 настай өсвөр үеийнхнийг салбарын номлогчоор дуудагч бөгөөд ямар ч цаг үед 6-12 салбарын номлогчид байнга дуудагдан үйлчилсээр ирсэн аж. Эдгээр номлогч дүүргийн хурлыг салбарын номлолын удирдагч ба бүрэн цагийн номлогчидтой тогтмол хийж хэвшжээ. Тэд хамтдаа “Миний сайн мэдээг номло” ном болон судруудаас судалж мөн англи хэл сурч байна.

Салбарын номлогчид хоёр хоёроороо хамтрагчид болж, шинэ ба идэвх суларсан гишүүдийнхээр зочилж, тэдэнд зааж мөн тэдэнтэй нөхөрлөдөг.



**Бямбажав Буцаж Эргэж номлогчдын уулзалтыг зохион байгуулсан. Салбарын номлогчид Нямбаяр, Нэргүй, Амартайван, Алтантуяа, Мөнхзул, Ганболд, Уугантуяа, ерөнхийлөгч Дамдиндорж, Азбаяр, Мартболд, Мөнхцэцэг**



**Гансүх, Азжаргал, Төрбат, Болормаа, Батхолбоо, ерөнхийлөгч Дамдиндорж, Оюунтуяа, Одноо, Ахлагч Батаа, Ахлагч Гантогтох**



**Дээд эгнээнд: Чингүүн, Одноо, Ариунжаргал, Оюунтуяа, Гансүх; доод эгнээнд: Салбарын номлолын удирдагч Нямбаяр болон Төрбат, Батхолбоо, Азжаргал**

Тэд уулзалтууд товлож, түүнийхээ дагуу үүргээ биелүүлдэг.

Ийнхүү өсвөр үеийнхэн номлолын насанд хүрэх үедээ номлолын ажлын зорилгын талаар бүрэн ойлголттой болж, “Миний сайн мэдээг номло” номоор аль хэдийнээ сургагдсан байдаг тул бүрэн цагийн номлогчид болж, Их Эзэндээ үйлчлэх тэдний хүсэл болоод гэрчлэл нь хүчирхэгжин, бэхждэг. Тэд “бүх дэлхийгээр явахад” бэлэн болдог юм.

2013 оны 1 – 5 сарын хооронд хоёр эгч Монголд номлолоо эхлүүлж, 4 номлогч

өөрсдийн номлолын дуудлагаа хүлээн авч, 6 – 8 сараас үйлчлэлдээ гарлаа.

Номлолын сүнс зөвхөн өсвөр үеийнхнээр хязгаарлагдсангүй. Энэ үеэр салбарын ахмад номлогчид бүрэн цагийн номлолд үйлчлэхээр номлолын маягтаа бөглөн илгээсэн бөгөөд тэд одоо номлолын дуудлагаа хүлээн авч, Сэлэнгэ салбарын ерөнхийлөгчөөр дуудагдан, Монголоо номлолд үйлчилж байна. Ахлагч Бодьцог ба Систер Пүрэв нар монголоос бүрэн цагийн номлолд үйлчилж байгаа анхны ахмад

хос номлогчид юм. Тэд бусад тэтгэвэртээ суусан хосуудад үлгэр жишээ болсон бөгөөд олон ахмад хос номлолд үйлчлэх талаар бодож сууна. ■

**Гансүх,  
Чингүүн,  
Ариунжаргал,  
Оюунтуяа,  
Батхолбоо**



**Хамтдаа англи хэл сурч байгаа нь**



**Ахлагч Бодьцог, Систер Пүрэв**